



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 2.1.3, 3.7.1, 3.7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Усны болон мөстөл судлалын инженерүүдийн мэргэшүүлэх сургалтыг 2018 оны 04 дүгээр сарын 2-6-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.


2. Ус, мөстөл судлалын инженерүүдийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг нэгдүгээр, зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтад хамрагдах инженерүүдийн ирэх, буцах унааны зардлыг төсвөөсөө гаргахыг холбогдох аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Ус судлал, мөстөл судлалын инженерүүдийн мэргэшүүлэх сургалтын томилолт, бусад зардалд 1,273,000 (нэг сая хоёр зуун далан гурван мянга) төгрөгийг тус газрын төсвийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч Д.Отгонбаярт зөвшөөрсүгэй.

5. Сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн дарга Д.Уламбаяр, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Г.Сарантуяа нарт даалгасугай

ДАРГА



С.ЭНХТҮВШИН

27711172